



Оюу Толгой ХХК

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа болон Байгаль орчны удирдлагын тогтолцооны журам

10-р хэсэг. Оюу Толгойн Төслийн талбай дахь Замын хөдөлгөөний Удирдлагын төлөвлөгөө

(СЗ Тээврийн хэрэгсэл ба жолоодлогын аюулгүй ажиллагааны стандарт)

ОТ Төслийн талбай дахь Замын хөдөлгөөний Удирдлагын төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2012.04.16Баримт бичгийн дугаар:
ОТ-10-СЗ-PLN-0001-МХувилбар:
1.2**1 ЗОРИЛГО**

Замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө (ЗХУТ) нь Рио Тинтогийн Оюу Толгой Төслийн талбай дээр жолооч, явган зорчигч нар замын хөдөлгөөний дүрэм журмыг даган мөрдөхийг баталгаажуулж байна.

Энэхүү ЗХУТ нь ОТ-Уурхайн Орох Хаалганаас эхлэн үйлчлэнэ. Энэхүү ЗХУТ-нд Орон Сууцны Тосгон, Уурхайн захиргааны барилга, Хөдөлгөөнт төхөөрөмжийн Засвар Үйлчилгээний газар болон Суурин Үйлдвэрийн Үйл ажиллагааны талбай хооронд явагдах тээврийн хэрэгслийн болон явган хүний хөдөлгөөн хамаарна. Ил уурхайн үйл ажиллагааны талбай Оюу Толгой Ил Уурхайн Зөвшөөрлийн дүрмээр зохицуулагдана.

ЗХУТ-ын зорилтууд нь:

- Бүх замын хэрэглэгч нарт аюулгүй орчинг хангах;
- Явган зорчигч болон ажилчдад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөс үүсэх замын хөдөлгөөний аюул эрсдлээс хамгаалах,
- Тээврийн хэрэгсэлд зохих зогсоолын талбайг хангах

Эдгээр зорилтуудад хүрэхийн тулд, Замын хөдөлгөөний удирдлагын Төлөвлөгөө дараах зүйлийг хангана:

- Явган хүний зам болон тээврийн хэрэгслийн замыг хоорондоо салгасан байх,
- Зогсоолын талбай сайн тодорхойлогдсон байх,
- Шаардлагатай газарт, орох боломжийг хязгаарласан байх,
- Зохих/хангалттай анхааруулах болон мэдээлэх тэмдэг суурилагдсан, төслийн талбай дахь замыг тод заасан зохих зааварчилгатай байх.

2 ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү журам нь Оюу Толгойн бүх ажилчид, гүйцэтгэгчдэд хамаарна. Үүнд Оюу Толгой ХХК-ий эзэмшиж байгаа эсвэл ашиглаж байгаа болон түүний гүйцэтгэгчдийн Оюу Толгойн төслийн талбай дээр эсвэл төслийн талбайгаас бусад газар Оюу Толгой ХХК-ий үйл ажиллагаанд ашиглаж байгаа бүх зам багтана.

3 ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Үүрэг	Хариуцлага
Ажилчид, Гүйцэтгэгчид болон Зочид	<p>Холбогдох хууль, улсын болон компаний дүрэм журмыг мэдэж, биелүүлж байх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Хүчинтэй механикжсан тээврийн хэрэгслийн жолооны үнэмлэхтэй байх шаардлага.• Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм.• СЗ Тээврийн хэрэгсэл ба Жолоодлого Стандарт• Монгол Улсын уул уурхайн дүрэм журам.• Архи болон бусад мансууруулах бодистай холбоотой шаардлагууд.• Төслийн талбайн замын хөдөлгөөний дүрэм журам.• Жолоочийн зөвшөөрөл

ОТ Төслийн талбай дахь Замын хөдөлгөөний Удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-ПЛН-0001-М	Хувилбар: 1.2

	<ul style="list-style-type: none"> СЗ Аюулгүй Ажиллагааны Стандартад заасны дагуу хөнгөн тээврийн хэрэгслийн шалгах шаардлага. Энэхүү Замын хөдөлгөөний Удирдлагын Төлөвлөгөөнд заасан зарчмууд
Супервайзор	<ul style="list-style-type: none"> Шаардлагатай үед, замын нөхцөл байдлыг засахад хэрэгтэй хөрөнгө, нөөцийг олгох. Жолооч болох оператор бүрийг сургалтанд, шаардлагатай бол дахин сургалтанд хамруулж байхыг хангах. Замын нөхцлийн сар болгон шалгаж байх.
Ахлах мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> Жолооч болох оператор бүрийг сургалтанд, шаардлагатай бол дахин сургалтанд хамруулж байхыг хангах. Ажилчид, гүйцэтгэгчдийн бүх үнэмлэхүүд хүчинтэй, ажилд тохиромжтой байгаа эсэхийг шалгах тогтолцоо, хяналтуудыг хангах. Шаардлагатай үед, замын нөхцөл байдлыг засахад хэрэгтэй хөрөнгө, нөөцийг олгох. Жолооч болох оператор бүрийг сургалтанд, шаардлагатай бол дахин сургалтанд хамруулж байхыг хангах.
Дараагийн Удирдлага Менежер / шатны (LOR)	<ul style="list-style-type: none"> Тухайн тээврийн хэрэгслийг жолоодох сургалтанд хамрагдсан, мэргэшсэн, шалгалтанд тэнцсэн, зохих үнэмлэхтэй байхаас өөр тохиолдолд хэн ч тухайн тээврийн хэрэгслийг жолоодох эрхгүй. Жил болгон болох аюулгүй жолоодлогын аргыг дэмжих арга хэмжээний тогтолцоо бүрдсэн байх ёстой бөгөөд ажлын зорилгоор жолоодох шаардлагатай бүх ажиллагсад үүнд хамаарна. Хурдны хязгаарыг сахиулна. Долоо хоног бүр үзлэг шалгалт хийнэ.

4 ЖУРАМ

4.1 Замын Загвар

Бүх зам нь СЗ Тээврийн хэрэгсэл ба Жолоодлого Стандартын загварын стандартуудын шаардлагад нийцэх ёстой.

- Зам нь тээврийн хэрэгслүүд бүх нөхцөлд мөргөлдөх эсвэл замаас гарах аюулгүйгээр явахаар хангалттай өргөн байх ёстой.
- Замын хашлага, тэмдэгийн шон, дугуй, хашлага зэргийг ашиглан зам зааглаж болно. Тээврийн хэрэгсэл замаас гадагш гарах аюулаас сэргийлж заавал аюулгүйн замын хашлагатай байх шаардлагатай.
- Түр зуурын замын ажилд Түр зуурын Замын хөдөлгөөний Удирдлагын төлөвлөгөө багтан орж болно, энэ нь энэхүү Замын хөдөлгөөний Удирдлагын төлөвлөгөөтэй нийцсэн нэмэлт төлөвлөгөө байна.

ОТ Төслийн талбай дахь Замын хөдөлгөөний Удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-ПЛН-0001-М	Хувилбар: 1.2

4.2 Тэмдэг

Бүх тэмдэг нь ЭМААБО-ны Стандарт Зарлал, Тэмдэгийн журам болон Монгол Улсын дүрэм журамд нийцэх ёстой.

Тэмдэг хэрэгслийг Замын хөдөлгөөний зохицуулалтын Диаграмд заасан байршил болон хоорондын зайд тохируулж тавих бөгөөд:

- Зөв тавьж чанга бэхэлсэн;
- Жолоочийн харах шугамын дагуу;
- Саадгүй Харагдах;
- Бусад тэмдэг хэрэгслийг жолоочийн харах шугамаас хаагаагүй;
- Явган зорчигч болон тээврийн хэрэгсэлд аюул учруулахгүй; мөн
- Замын хөдөлгөөнийг буруу зам руу оруулахгүй байна.

4.3 Хурдны Хязгаар

Бүх тээврийн хэрэгсэл нь заасан хурдны хязгаарыг хэтрүүлэхгүйгээр явна. Хурдны хязгаарыг талбай бүрийн тусгай шаардлагад заасан байна.

Хурдны хязгаарыг Тээврийн хэрэгсэл ба Жолоодлого Стандартын заалт 5.2-д заасны дагуу тогтмол хянан үзэж байна. Төслийн талбай дээр тогтмол хурдыг хэмжих үзлэгүүд хийгдэнэ. Хурд хэтрүүлсэн жолооч нарт сахилгын арга хэмжээ авна.

4.4 Тээврийн хэрэгслийн Шаардлага

- Тээврийн хэрэгсэл болон жолоодлогын аюулгүй байдалд нөлөөлөх нөхцөл байдлын ба зан төлвийн хүчин зүйлүүдийг тодорхой тогтоохын тулд бүх тээврийн хэрэгсэлд эрсдлийн цогц дүн шинжилгээ хийх ёстой. Дүн шинжилгээ нь:
 - Ашиглагдах тоног төхөөрөмжийн операторууд болон техникийн үйлчилгээний ажилтнуудыг оролцуулна; мөн
 - Ачилт, буулгалт, жолоочийн харагдах орчин, тоормосны эвдрэл, хаймар дугуй хагарах, операторууд болон техникийн үйлчилгээний ажилтнуудын орох/ гарах зэрэг аюулгүй үйл ажиллагааны бүх асуудлыг мөн авч үзнэ.
 - Тоног төхөөрөмж нь ОТ Стандартад нийцэхийг хангана.
- Ажлын зорилгоор ашиглагдаж байгаа бүх хөнгөн тээврийн хэрэгсэл нь, эрсдлийн дүн шинжилгээгээр өөрөөр заагаагүй бол, Хөнгөн Тээврийн Хэрэгслийг Ажиллуулах журам болон Рио Тинтогийн тээврийн хэрэгсэл ба жолоодлого зааварчилгааны бүх шаардлагуудыг дагаж мөрдөнө.
- Оюу Толгой уурхайн талбай дээр болон Оюу Толгой Үйл ажиллагааны хяналтан дор байгаа ойр талбайд ашиглахаас өмнө бүх тээврийн хэрэгслийг үзлэгт оруулж батлуулна. Үзлэгийг Оюу Толгой Хөдөлгөөнт Тоног Төхөөрөмжийн засвар үйлчилгээний хэлтсийн шаардлагын дагуу хийх бөгөөд Рио Тинтогийн Оюу Толгойн тоног төхөөрөмжийн техникийн нөхцөлд нийцэж байгаа эсэхийг шалгана.

4.5 Үзлэг

- Тээврийн хэрэгслийн үзлэгийг;
 - Хүргэлтийн өмнөх – бүх тээврийн хэрэгсэлд, талбай дээр ажиллахад тохирч байгаа эсэхийг шалгана

ОТ Төслийн талбай дахь Замын хөдөлгөөний Удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-ПЛН-0001-М	Хувилбар: 1.2

- Ажиллуулахын өмнөх – өдөр бүр эсвэл ээлж бүр, эрсдлийн дүн шинжилгээний дагуу
- Ажиллуулсны дараа – өдөр бүр ээлжийн дараа
- Засвар үйлчилгээ хийхээс өмнөх - засвар үйлчилгээгээр засах аливаа доголдлыг тогтоохын тулд
- Ажлын зорилгоор ашиглаж байгаа тээврийн хэрэгсэл бүр Зөвшөөрлийн Шошго наалттай байх ёстой. Энэхүү наалтыг Говь дэлгүүр олгоно.
- Бүх тээврийн хэрэгсэлд:
 - Хөдөлгөөнд оролцохын өмнөх шалгах хуудас
 - Дугуйн тээглүүр байна.
- Төслийн талбайгаас гадна болон талбай хооронд ашиглагдах тээврийн хэрэгсэлд мөн:
 - Аюулгүйн гурвалжин 1 багц
 - Дугуйн тээглүүр 1 багц
 - 1 ажлын хантааз
 - 1 гар чийдэн
 - Нам хүчдэлтэй дугуй солих Стандарт ажлын журам

4.6 Холбоо

Оюу Толгой төслийн талбайд ашиглах бүх уурхайн тээврийн хэрэгсэл, дагалдуулж явахаас бусад тохиолдолд, заавал ажиллагаатай UNF долгионы 2 талт радиогоор тоноглогдсон байх ёстой.

Ил уурхайн үйл ажиллагааны сувгийг ил уурхайн бүх зам дээр явахад ашиглана. Зөвшөөрөл аваагүй бол, жолоодлогын үед гар утсаар ярихыг хориглох бөгөөд Гар Утас Ашиглах Бодлогыг дагаж мөрдөнө.

4.7 Зогсоол

Хөнгөн тээврийн хэрэгсэл болон хөдөлгөөнт уурхайн төхөөрөмжид хэвийн замын хөдөлгөөний урсгалаас чөлөөтэй газарт зогсоолын байр гаргах бөгөөд энэ нь өөр өөр хэмжээ, төрлийн тээврийн хэрэгсэл, явган хүний хөдөлгөөнийг хоорондоо харьцахыг багасгах зорилготой юм.

4.7.1 Зориулалтын Зогсоолын Талбай

Хөнгөн тээврийн хэрэгсэл эсвэл хөдөлгөөнт уурхайн төхөөрөмжийн зогсоолын зориулалттай талбайг дараах зүйлийг харгалзан үзэн зохиож барина;

- Хөнгөн тээврийн хэрэгсэл, уул уурхайн төхөөрөмжийг хоорондоо салгах,
- Гэнэтийн тээврийн хэрэгслийн хөдлөлтөөс сэргийлэх дугуйн шуудуу эсвэл далан,
- Тээврийн хэрэгслийн харагдах орчныг нэмэгдүүлэхээр гарах цэгүүдийг байрлуулж барих,
- Орох, гарах цэгийг заасан тэмдгийн самбарууд,
- Зогсоолын талбай дахь хурдны хязгаарыг заасан тэмдгийн самбарууд.
- Тээврийн хэрэгслийн болон явган зорчигчийн аюулгүй хөдөлгөөнийг хангах зохих талбайн гэрэлтүүлэг,
- Газрын нөхцөл байдлыг тогтвортой хадгалах зорилгоор газрын гадаргуу болон ус сувгийг тохируулна,
- Хэрвээ боломжтой бол, тээврийн хэрэгслийн чиглэл урсгалыг хянаж, бүх орж байгаа эсвэл зогсоолын талбайд явж байгаа тээврийн хэрэгсэл нэг чиглэлд явахаар байна,

ОТ Төслийн талбай дахь Замын хөдөлгөөний Удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PLN-0001-М	Хувилбар: 1.2

- Хэрвээ боломжтой бол, бүх явган зорчигчийн хөдөлгөөнтэй талбайд, тээврийн хэрэгслийг ар тал руу зогсоосон байна (урагшаа жолоодож гарахаар).
- Өөрөөр зөвшөөрөөгүй бол, төслийн талбай дахь бүх тээврийн хэрэгслийг зориулалтын зогсоолын талбайд тавина

4.7.2 Зориулалтын бус зогсоолд тавих арга

Зориулалтын зогсоолын талбайгаас өөр газар тээврийн хэрэгслийн зогсоолд тавихаар бол, дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ;

- Талбай нь замын хөдөлгөөнөөс чөлөөтэй байх бөгөөд ачааны машины тэвшээс асгарах зүйл, ажиллаж байгаа бусад тоног төхөөрөмжийн хөдөлгөөнөөс сэргийлэхийн тулд хангалттай зайд байна,
- Тээврийн хэрэгслийг ирж байгаа замын хөдөлгөөн тод харагдах байдлыг хангахаар байрлуулна,
- Гэнэтийн хөдлөлтөөс сэргийлэхийн тулд, тогтвортой хөдөлгөөнгүй байрлалд оруулж тээврийн хэрэгслийг зогсоолд тавина,
- Тээврийн хэрэгслийн ослын гэрэл ба/эсвэл тусгай гэрэл дохиог асаана.

4.7.3 Зогсоолд тавих арга

- Гэнэтийн хөдлөлтийг хаасан, тогтвортой хөдөлгөөнгүй байрлалд оруулж тээврийн хэрэгслийг зогсоолд тавина. Тогтвортой хөдөлгөөнгүй байрлалыг шалгахын тулд, бүх тоормосны системийг салгаж, тээврийн хэрэгслийг араанаас салгасан байна. Ийм нөхцөлд тээврийн хэрэгсэл өнхрөхгүй бол, тогтвортой хөдөлгөөнгүй болсон гэж үзнэ.
- Төвгөр газар, шуудуу, шороон далан эсвэл аливаа тогтмол тогтоосон төхөөрөмжийг ашиглан тээврийн хэрэгслийг тогтвортой хөдөлгөөнгүй болгож чадахгүй бол, дугуйн тээглүүрийг ашиглах шаардлагатай.
- Нэвт гарах зогсоолыг ашиглаагүй газарт бүх тээврийн хэрэгслийг ар тал руу зогсоолд тавьж, гарахдаа урагшаа жолоодохоор тавина.
- Бүх тээврийн хэрэгсэлд зогсоолд тавих зөвлөсөн аргуудыг заасан Стандарт Ажиллуулах Журмуудыг боловсруулна.

4.8 Ерөнхий Жолоодлогын Дүрэм

Доорхи дүрэм тээврийн хэрэгслийг ажиллуулахад хамаарна:

- Өөрөөр заагаагүй бол, Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийг бүх Оюу Толгойн үйл ажиллагааны талбайд дагаж мөрдөнө.
- Бүх хурдны болон чиглэлийн тэмдэг дагана,
- Зам дээр баруун талыг барьж явна,
- Ачааны машины тэвшинд хүн тээвэрлэж болохгүй,
- Тээврийн хэрэгсэлд архи болон мансууруулах бодис тээвэрлэж болохгүй
- Төслийн талбай дээр болон бусад газар компанийн тээврийн хэрэгсэл жолоодох үед цусан дахь архи, мансууруулах бодисын агуулга нь бүх цагт тэг байх ёстой
- Тээврийн хэрэгслийн зорчигч бүрт суудлын бүс олгох бөгөөд бүх цагт бүсээ зүүх ёстой.
- Газар шорооны хүнд хөдлөх төхөөрөмжийг ажиллуулахад гар утсыг ашиглахыг хориглоно.
- Улаан анивчих гэрэл дохио ба/эсвэл дуут дохиогоор тоноглогдсон гэнэтийн тусламжийн тээврийн хэрэгслүүдэд төслийн талбай дээр бусад бүх тээврийн хэрэгсэл зам тавьж өгнө.
- Цаг агаарын байдалд тохируулан, 4 дугуй хөтлөгчийг төслийн талбайн бүх битүүмжлээгүй замд ашиглахыг зөвлөмж болгоно.

ОТ Төслийн талбай дахь Замын хөдөлгөөний Удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-ПЛН-0001-М	Хувилбар: 1.2

4.9 1.11 Хөдөлгөөнийг хоорондоо салгах

- Боломжтой бол, явган хүний болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хоорондоо салгаж, хамгаалалтын хаалт тавина.
- Зохих газарт явган хүний зориулалтын зам гаргаж, тэмдгийн самбар болон замын тэмдэглээг ашиглан явган зорчигчийн аюулгүй бүсийг зааж өгнө.
- Явган хөдөлгөөн их байгаа газарт тээврийн хэрэгслийн хурдны хязгаарыг багасгана.
- Шаардлагатай бол, хурдыг хязгаарлах хэрэгслийг ашиглана.

4.10 1.12 Эвдрэл ба засвар

Рио Тинтогийн СЗ Стандартад нийцээгүй бол, тээврийн хэрэгслийг чирэхийг хориглоно. Стандарт ажлын журам байхгүй бол, аливаа хүнд төхөөрөмжийг чирэхээс өмнө Аюул эрсдлийн үнэлгээ хийх ёстой. Аюул эрсдлийн үнэлгээ хийсэн хариуцсан хүн нь аливаа хэвийн бус жолоодлогын нөхцөл гарсан байвал (тухайлбал, хүчлүүртэй жолоо эсвэл тоормос ажиллахгүй г.м.) жолооч нарт мэдэгдэнэ.

Механик эсвэл цахилгааны эвдрэлтэй, засах эсвэл чирэх шаардлагатай бол;

- Бусад тээврийн хөдөлгөөнөөс хол зогсоолд тавина;
- Төлөвлөгдөөгүй хөдөлгөөнөөс сэргийлж тогтвортой болгоно;
- Аваарын гэрлийг асаана,
- Тухайн зам дээр явж байгаа бусад жолооч нарт зогссон тээврийн хэрэгслийн байршлыг радиогоор мэдэгдэнэ, мөн
- Жолооч нь тусламж иртэл тээврийн хэрэгсэлд сууж байна.
- Чирэхээр зориулагдаагүй бол, аливаа тээврийн хэрэгслийг тоног төхөөрөмж чирэхэд ашиглаж болохгүй. Татлага, гинж болон чирэх эсвэл засах зориулалттай хэрэгсэл өөр зорилгоор ашиглуулахгүйн тулд тусгай шошготой эсвэл тэмдэглэгээтэй байна.
- Боломжтой бол, засвар хийхээс өмнө тээврийн хэрэгслийг замаас чирж гаргах шаардлагатай.
- Ачаа зөөх зам дээр чирэх ажиллагаа эхлэхээс өмнө, бүх зам дээр байгаа жолооч нарт радио холбооны системээр мэдэгдэнэ.

4.11 Сургалтын шаардлага

Төслийн талбай дээр жолоодоход тавих зайлшгүй шаардлага:

- Хүчинтэй жолооны үнэмлэх
- ОТ ЭМААБО-ны болон Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгааны сургалтанд хамрагдсан байх, хугацаа нь хүчинтэй байх
- Ил уурхайн жолоочийн үнэмлэхтэй бол, жил болгон болох Ил уурхайн Зөвшөөрлийн үнэлгээнд орсон байх

5 ТОДОРХОЙЛОЛТ

Тээврийн хэрэгсэл: Ажлын зорилгоор ашиглагдах аливаа механикжсан дугуйтай тээвэр, үүнд хөнгөн тээврийн хэрэгсэл болон хөдөлгөөнт төхөөрөмж орсон байна; харин галт тэрэгний зүтгүүр болон төмөр замын аливаа машин үүнд хамаарахгүй.

Ёстой: Шаардлагыг заавал биелүүлнэ.

Байвал зохино: Шаардлагыг зөвлөмж болгож байна

ОТ Төслийн талбай дахь Замын хөдөлгөөний Удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-PLN-0001-М	Хувилбар: 1.2

Хөнгөн тээврийн хэрэгсэл: 4.5 тонноос бага нийт жинтэй аливаа хуурай газрын тээврийн хэрэгсэл.

Хүнд тээврийн хэрэгсэл: Том тээврийн хэрэгсэл болон уурхайн үйл ажиллагаанд ашиглагдах, талбайн нэг хэсгээс нөгөө хэсэг рүү өөрийн хүчээр явж чадах хөдөлгөөнт төхөөрөмж.

Харах хүнгүй тээврийн хэрэгсэл: Тухайн тээврийн хэрэгслийг ажиллуулах мэргэшсэн ажилтан тухайн тээврийн хэрэгслийн жолоон дээр байхгүй бол уг тээврийн хэрэгслийг харах хүнгүй байна гэж тооцно.

Тогтвортой хөдөлгөөнгүй: Хөдөлгөөнт тоног төхөөрөмжийг араг салгаж орхисон, тоормос, түүнчлэн гар тоормос, ашиглаагүй үед уг хөдөлгөөнт төхөөрөмж нь өнхрөхгүй эсвэл хөдлөхгүй байх байрлалыг тогтвортой хөдөлгөөнгүй гэж үзнэ.

6 ЛАВЛАГАА БА ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

	Нэр	Байршил
Хуулийн болон бусад шаардлага	СЗ Тээврийн хэрэгсэл ба жолоодлого стандарт	Проспект
Оюу Толгой ЭМААБО Удирдлагын Систем	Элемент 10 – Үйл ажиллагааны хяналт	ЭМААБО-ы Портал хуудас
	ОТ-10-PRC-0005-E-HSE Стандарт зарлал, тэмдгийн журам	
	ОТ-10-СЗ-PRC-0005-E-Замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө	
	ОТ-10-СЗ-PRC-0004-E-Дугуй, обудны удирдлагын төлөвлөгөө	
	ОТ-10-СЗ-PRC-0006-E-Лицензи, зөвшөөрөл авах Журам	
	ОТ-10-СЗ-PRC-0002-E-Хөнгөн тээврийн хэрэгслийн Журам	
	ОТ-10-СЗ-PRC-0003-E-Хүнд тээврийн хэрэгслийн журам	
	ОТ-10-СЗ-PRC-0001-E-Зам барих болон замын засвар үйлчилгээний журам	

ОТ Төслийн талбай дахь Замын хөдөлгөөний Удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16	Баримт бичгийн дугаар: ОТ-10-СЗ-ПЛН-0001-М	Хувилбар: 1.2

7 БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Баримт бичгийн нэр	ОТ-10-СЗ-ПЛН-0001-М- ОТ төслийн талбайн замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө.docx
Тайлбар	ОТ төслийн талбайн замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө
Зохиогч (д)	СЗ Хариуцагчдын Баг
Боловсруулсан огноо	2012.03.01
Баталсан	Эндрю Миллер
Баталсан огноо	2012.04.16
Өөрчлөлт оруулсан дугаар	##

Эрсдлийн түвшин	Үнэлгээ хийсэн огноо	Эрсдлийн үнэлгээ хийсэн	Хяналт хийх давтамж	Дараагийн хяналт хийх огноо
Дунд	2012.04.16	Эндрю Миллер	2 жил тутам	2014.04.16

Хувилбар	Өөрчлөлт хийсэн огноо	Зохиогч (д)	Баталсан	Өөрчлөлтийн тайлбар
1.0	2012.04.16	СЗ Хариуцагчдын Баг	Эндрю Миллер	Анх зохиосон
1.1	2012.04.16	СЗ Хариуцагчдын Баг	Эндрю Миллер	Баталсан
1.2	2012.12.28	Н. Тогтуур	Б. Долгор	Бичиг баримтанд хяналт хийгдсэн бөгөөд утга санааг нь өөрчлөөгүй болно